



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70592225 Цахим хаяг: Oyun-Erdenet@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn Аудитор: Б.Мягмарсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Myagmarsurenby@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	8
4.1 Ерөнхий зүйл.....	8
4.2 Материаллаг байдал.....	8
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	8
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
4.5.1 Завсрын аудитын талаар	8
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
5. Аудитын илрүүлэлт.....	8
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <p>ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нутгийн удирдлагын орлон, 7-р баг, Сайнцагаан сум Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208. Цахим хаяг: dundgovy@audit.gov.mn</p>	<p>ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА О.УУГАНБААТАР ТАНАА</p>
№ <u>4025.03.85</u> № <u>89</u>	
тантай _____ -ны № _____ -т	

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Баянжаргалан сумын Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлбэл зохих замын хураамж, хандив тусламжийн орлого 93.2 сая төгрөгийг ТББ-ын дансанд хүлээн авч, зориулалт бусаар зарцуулсан.
- Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 33.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 25 дугаар зүйлийн 25.7, 25.8, 25.10, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 3.4 дахин их, шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой

4825020303

зүйлийн талаар тодруулахад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, сумын бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.4 дахин өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2 төсвийн байгууллагын 5 албан хаагч 41.7 сая төгрөгийн дэмжлэг авсан байна.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарч, тус сумын Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 34.9 сая төгрөгийн хөрөнгө, 22.6 сая төгрөгийн бараа материал, 9.0 сая төгрөгийн авлагыг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэн бүртгэсэн байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдэл 2023 оны аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эцсийн үлдэгдлээс зөрүүтэй байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл, улсын төсвийн байгууллагын төвлөрүүлсэн дүнг устгал хийсэнтэй холбоотой байна.

Уг үйл явцуудыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 66 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 83.7 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд

уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,718,344.0	1,463,897.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,237,736.7	972,792.1
33	АВЛАГА	233,160.2	166,772.7
35	БАРАА МАТЕРИАЛ	82,700.8	131,586.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	164,746.2	192,746.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,317,440.2	2,334,960.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,317,440.2	2,334,960.0
39200	Биет хөрөнгө	1,295,101.2	2,313,344.6
39300	Биет бус хөрөнгө	22,339.0	21,615.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,035,784.2	3,798,857.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	44,325.1	53,091.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,325.1	53,091.6
41300	Өглөг	44,325.1	53,091.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,991,459.0	3,745,766.1
51	Засгийн газрын хувь оролцоо	2,991,459.0	3,745,766.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	452,108.8	452,108.8
51200	Хуримтлагдсан үр дүн	2,334,194.5	3,088,501.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,155.7	205,155.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,035,784.2	3,798,857.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,821,831.8	2,888,077.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	822,513.6	1,178,351.2
110	Орлогын албан татвар	174,073.9	395,848.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	174,073.9	395,848.3
113	Хөрөнгийн албан татвар	41,982.6	67,228.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	606,457.1	715,274.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	226,290.4	840,936.4
120	Нийтлэг татварын бус орлого	226,290.4	840,936.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	773,027.9	868,790.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	917,006.7	1,782,179.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	917,006.7	1,782,179.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	891,631.5	1,613,569.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,212.9	578,735.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,339.4	72,876.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,001.5	89,842.8
2104	Хангамж, бараа материалын зардал	58,531.6	79,894.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300.0	124,176.2
2107	Томилолт, зочны зардал	14,862.0	28,516.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,186.8	50,482.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316,197.3	589,046.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,375.2	168,610.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	904,825.2	1,105,898.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	304,931.5	348,410.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	599,893.6	757,488.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,391,565.4	2,391,565.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,391,565.4	2,391,565.4
9	Тайлант үеийн үр дүн	599,893.6	599,893.6
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,991,459.0	2,991,459.0
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,991,459.0	2,991,459.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,180.8	-3,180.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,988,278.2	2,988,278.2
19	Тайлант үеийн үр дүн	757,488.0	757,488.0
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,745,766.1	3,745,766.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,737,121.4	2,393,418.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	822,513.6	1,178,351.2

Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

110	Орлогын албан татвар	174,073.9	395,848.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	174,073.9	395,848.3
113	Хөрөнгийн албан татвар	41,982.6	67,228.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	606,457.1	715,274.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,395.0	13,000.7
1181	Газрын төлбөр	596,062.1	702,274.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	141,579.9	346,276.9
120	Нийтлэг татварын бус орлого	141,579.9	346,276.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	773,027.9	868,790.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	667,401.9	1,461,558.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	667,401.9	1,461,558.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	641,931.4	1,292,948.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,212.9	578,411.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,339.4	72,876.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,415.4	89,467.8
2104	Хангамж, бараа материалын зардал	46,726.6	54,185.6
2105	Норматив зардал	600.0	1,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,405.8	124,176.2
2107	Томилолт, зочны зардал	14,772.0	28,516.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,731.5	50,482.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,727.7	293,732.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,470.6	168,610.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,069,719.5	931,859.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	319,381.1	1,196,804.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	319,381.1	1,196,804.4
2200	Дотоод эх үүсвэрээр	319,381.1	1,196,804.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-319,381.1	-1,196,804.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-137,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	137,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	613,338.4	-264,944.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	624,398.4	1,237,736.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,237,736.7	972,792.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,196,706.1	2,468,447.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,543,502.0	1,312,944.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,486,317.0	1,256,517.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	613,302.0	578,411.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,192.5	72,876.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,091.8	86,410.8
2104	Хангамж, бараа материалын зардал	56,073.7	49,926.4
2105	Норматив зардал	1,100.0	1,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	183,234.1	142,920.0
2107	Томилолт, зочны зардал	28,976.0	28,516.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,086.7	11,405.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	416,260.2	284,952.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,185.0	56,427.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,185.0	56,427.0

Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,567,348.3	1,155,502.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	85,855.8	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,196,706.1	2,565,457.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	820,415.5	787,598.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,676,493.7	1,458,880.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	699,796.9	318,978.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	641,467.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	738,477.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,191.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,191.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,087.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,057.1
2104	Хангамж, бараа материалын зардал	4,259.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,077.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,693.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,103.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,103.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81,191.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,191.5

3. Аудитын илрүүлэлт

3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дундговь аймгийн Баянжаргалан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй. Харин байгаль хамгаалах сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 33,589.3 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгах хугацаатай 1 албан шаардлагыг хүргүүлсэн.

3.1.1 Албан шаардлага

Санхүүгийн тайлан дахь 33,589.3 /гучин гурван сая таван зуун наян есөн мянга гурван зуу/ мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	-----------------------------	--------------------------	-------------------------

Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

А	1	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
2	3	4	5	7	8	9	10		
1	Засаг даргын Тамгын газар	1	1		1				
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
НИЙТ		6	1	5	1				

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт дүнгээр 2,348,642.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,154,727.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 45,488.7 мянган төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 148,426.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлагыг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 8.3 хувийг залруулагдаагүй, 91.7 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	2,154,718.6	2	2,154,718.6			2	2,154,718.6				
Дүн	2	2,154,727.6	2	2,154,727.6	0	0.0	2	2,154,727.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	3	5,679.2	1	203.1	2	5,476.1						
ИТХ	1	898.0			1	898.0						
ХХС	1	6,733.3	1	6,733.3								
ОНХС	5	93,202.3	3	38,552.3	1	54,650.0			1	0.0		
БХС	1	33,589.3			1	33,589.3						
Нийт дүн	11	140,102.1	5	45,488.7	5	94,613.4	0	0.0	1	0.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ХХС	1	0.0			1	0.0						
Дүн	1	0.0			1	0.0						
2. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ЗДТГ	1	53,812.6			1	53,812.6						
Нийт дүн	2	53,812.6	0	0.0	2	53,812.6						